

## ӨГҮҮЛЭЛ

## НҮБ-д Монголын асуудлыг хэлэлцсэн нь (1946-1961 он): БНМАУ-ын гишүүнчлэлийн асуудлаарх ЗХУ, АНУ-ын байр суурийн хувьсал өөрчлөлт

**Цэдэндамбын Батбаяр**

Академич, доктор Sc.D,

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Улаанбаатар, Монгол Улс  
[tsedendamba.bud@gmail.com](mailto:tsedendamba.bud@gmail.com)

**Хураангуй:** Тус өгүүлэлд “Хүйтэн дайн”-ы нөхцөлд НҮБ дахь Монголын асуудлаар ЗХУ, АНУ зэрэг их гүрнүүдийн байр суурь, тэдний зөрчил, сөргөлдөөн, эвлэрлийн уялдаа холбоог авч үзэх болно. Зохиогч НҮБ-д Монголын элссэн түүхэн үйл явцыг гурван үед буюу 1946-1948 оны эхний үе, 1950-1953 оны Солонгосын дайны үе, 1955-1961 оны НҮБ-д элссэн төгсгөлийн үе хэмээн задлан авч үзэв. “Хүйтэн дайны” үед их гүрнүүд Нэгдсэн Үндэстний байгууллагыг өөрсдийн улс төрийн зорилгод дур зоргоор ашиглаж байсан нь олон улсын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд саад болж, БНМАУ зэрэг орнуудыг НҮБ-д элсэх асуудлыг олон жилээр хойш татаж байв. БНМАУ-ын хувьд НҮБ-д элсэх нь туурга тусгаар улсын үндэсний бахархал, хууль ёсны эрхээ хүлээн зөвшөөрүүлэх, олон улсын нэр хүндээ өсгөх ач холбогдолтой байлаа. Тэр нөхцөлд Москва, Вашингтон хоорондын яриа хэлэлцээний шинж чанар нь глобалъ болон бүс нутгийн асуудлыг шийдвэрлэхэд гол хүчин зүйл болж ирсэн бөгөөд жижиг орны хүсэл эрмэлзэл олон улсын хэрэгт тэр болгон үр нөлөөтэй байж чадахгүй байв.

**Түлхүүр үгс:** НҮБ, ЗХУ, АНУ, “хүйтэн дайн”, БНМАУ-ын гишүүнчлэл, Гоминьданы Хятадын вето эрх

БНМАУ Нэгдсэн Үндэстний Аюулгүйн Зөвлөлийн хуралдаанаар 15  
Байгууллагад 1946 оноос эхлэн жилийн хугацаанд 13 удаа хэлэлцүүлэг  
нийт 5 удаа элсэх өргөдлөө гаргаж, хийгдсэн байна. Улмаар 1961 оны 10

Received: 04 May, 2021; Accepted: 05 July, 2021

<https://orcid.org/0000-0001-7259-9540>



<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

дугаар сарын 25-ны өдөр Аюулгүйн Зөвлөлийн гишүүд санал нэгтэй дэмжин БНМАУ-ыг НҮБ-ын гишүүн болгохыг дэмжсэн зөвлөмжийг Ерөнхий Ассамблейд өгснөөр мөн оны 10 дугаар сарын 27-ны өдөр НҮБ-ын гишүүн болсон юм. Монгол Улс

Нэгдсэн Үндэстний Байгууллагад элссэнээр үе үеийн эрх орончдын хүсэл мөрөөдөл, Монголоо гэх төрийн зүтгэлтнүүд, дипломатууд, шашны хутагтууд, жирийн иргэдийн зүтгэл тэмцэл биелэлээ олсон билээ.

### Эхний үе: БНМАУ НҮБ-д элсэхээр тэмцсэн нь (1946-1948 он)

ЗСБНХУ-аас 1945 оны 8 дугаар сарын 9-ний өдөр Японд дайн зарласан билээ. Түүний дараахан БНМАУ-аас 8 дугаар сарын 10-ны өдөр Японд мөн дайн зарлав. Энэ тухай БНМАУ-ын Бага хурал, Засгийн газраас гаргасан тунхаглалд “Монголын ард түмний хэдэн зуун жилийн турш өөртөө бүрэн эрх чөлөөтэй тусгаар тогтнохын төлөө зорьж ирсэн санаа сэтгэлийг дагуулан Монгол овогтон нэгэн гэр улс болж айл зэргэлдээх ардчилсан улс лугаа найртай сайхнаар оршин суухыг хүсэж ирснийг үндэслэж ... нийтийн дайсныг түргэнээр бүрмөсөн цохиж устгах гэсэн ардчилсан улсууд ба эрх чөлөөг эрмэлзэгч дэлхийн ард түмний нэгэн санаа зорилгоор бахархан зоригжиж нэгдсэн үндэстний үйлсэд өөрийн тус нэмрийг оруулахын тулд нэгдсэн үндэстний талд оролцон Япон улстай байлдах ариун дайныг эрхэмсгээр зарлан...” буйгаа мэдэгджээ.<sup>1</sup>

Зөвлөлт-Монголын морьт механикжуулсан групп өмнөө тавьсан үүргээ амжилттай биелүүлж, 1945 оны 8 дугаар сарын 13-ны өдөр Долнуурыг, 19-ний өдөр Жэхэг, 21-ний өдөр Чуулалт Хаалгыг эзэлж, Суйюань-Бээжин хавьд байсан Японы

цэргийн бүлэглэлийг Манжуур дахь гол хүчээс нь таслах үүргээ амжилттай биелүүлжээ. Зөвлөлт-Монголын цэрэг 8 дугаар сарын 22-ны өдөр Жанчхүү буюу Чуулалт хаалга хотод орж иржээ.

1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Монгол даяар улс орон цаашид хэрхэн орших асуудлаар санал асуулга явуулж, Монголын ард түмэн тусгаар тогтнолоо илэрхийлсэн хэвээр хадгалан хөгжих хүслээ 100 хувь илэрхийлсэн юм. Санал асуулгын дүнг ЗХУ, Хятад улсад албан ёсоор мэдэгдсэний дараа 1946 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр Чан Кайши-гийн Засгийн газар БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч, мөн оны 2 дугаар сарын 13-нд БНМАУ, Дундад Иргэн улсын хооронд дипломат харилцаа тогтоох болон дипломат төлөөлөгч харилцан суулгах тухай ноот бичгийг солилцжээ.

Энэ зорилгоор БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгч Ерөнхий сайдын орлогч Ч.Сүрэнжав тэргүүтэй, ГЯЯ-ны орлогч сайд Н.Лхамсүрэн нарын Монголын дипломатууд ДИУ-ын нийслэл Чунцинд 1946 оны 2 дугаар сард очсон байна. ДИУ-ын Үндэсний төв Засгийн газрын Ерөнхийлөгч Чан Кайши 2 дугаар сарын 10-ны

<sup>1</sup> “Үнэн” сонин. 1945.08.10.

өдөр Ч.Сүрэнжав нарыг хүлээн авч уулзан: “Хятад, Монгол хоёр улс бол үүний урьд /Манж Чин улсын захиргаанд хоёулаа ноёрхогдож байсан үед Ц.Б./ нэг гэр бүлд, нэг захиргаанд захирагдаж байсан юм. Японы империализмыг эсэргүүцсэн чөлөөлөх дайны үед бид хамтран байлдаж байлаа. Одоо БНМАУ өрх гэр, өмч хөрөнгөө авч үндэсний бүрэн эрхт тусгаар тогтносон улс болж байна” гэжээ.<sup>2</sup>

Энэ үйл явдлаас 4 сарын дараа БНМАУ-ын Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Х.Чойбалсан 1946 оны 6 дугаар сарын 21-ний өдөр НҮБ-ын гишүүн болох өргөдлөө өгч олон улсын түгээмэл үйл явцад оролцоход чиглэсэн анхны алхмаа хийжээ. Өргөдөлдөө 25 жилийн туршид тусгаар тогтносон улсын бүх чанарыг бүрэлдүүлэн бататгаж, улмаар дэлхийн хоёрдугаар дайны үед нэгдсэн үндэстнүүдийн үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан Монгол улс НҮБ-ын гишүүн болох эрхтэйг нотлон тайлбарласан байв.<sup>3</sup>

1946 оны 7 дугаар сард НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс байгуулсан шинэ гишүүн элсүүлэх хороогоор Монголын өргөдлийг урьдчилан хэлэлцэхэд АНУ, Австрали, Египет, Нидерланд, Их Британи зэрэг улсын төлөөлөгчдийн гаргасан саналын үндсэн дээр БНМАУ-ын талаарх мэдээлэл хангалттай бус байгаа тул нэмэгдэл мэдээллийг доорх асуудлаар авахыг хүсэж НҮБ-

ын Ерөнхий нарийн бичгийн даргаас БНМАУ-ын ГЯЯ-ны сайдад асуулга ирүүлж байжээ. Үүнд:

Эдүгээ улс төр, эдийн засаг, нийгэм ба соёл боловсролын харилцааг оролцуулан Монголын гадаад харилцаа ямар байгаа болох,

Гадаад харилцаагаа хөгжүүлэх, ялангуяа дипломатын ба консулын төлөөлөгчдийг солилцох талаар Монголын Засгийн газар ямар бодлоготой байна вэ?

Үүнээс урьд Хятад, СССР хоёроос гадна дипломат ба консулын төлөөлөгчдийг солилцох тухай өөр ямар улсуудаас санал тавьсан ба ямар хариуг өгч байсан,

Тус Хорооны зүгээс а/ БНМАУ-ын Үндсэн хууль, засгийн хэлбэр ба гадаад харилцаанд хамаарагдах бусад баримт сэлт, б/ улсын төсөв, ялангуяа гадаад харилцааг санхүүжүүлэх талаар тодорхой мэдээлэл авахыг хүссэн байна.<sup>4</sup>

БНМАУ-ын Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч Ю.Цэдэнбал, ГЯЯ-ны орлогч сайд Н.Лхамсүрэн, хэлтсийн дарга Б.Жаргалсайхан нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид мөн оны 8 дугаар сард НҮБ-ын төв байр байрлах Нью Йоркт очиж, гишүүн элсүүлэх Хорооноос тавьсан асуулгын дагуу БНМАУ-ын талаар нэмэгдэл мэдээлэл хийж, манай өргөдлийг Аюулгүйн Зөвлөлд хэлэлцэхэд ажиглагчаар оролцжээ.<sup>5</sup>

2 С.Рэнцэнсоном. БНМАУ, ДИУ-ын хооронд 1946 онд хэвийн дипломат харилцаа тогтоосон тухай бяцхан дурсамж. "Ертөнцийн чихнээ: Монгол элч нарын дурсамж". УБ., 1991. 92-94-р тал.

3 ГХТА, фонд 61, данс 01. хн 22. БНМАУ-аас НҮБ-д элсэхээр бичсэн өргөдлүүд. х. 1-2.

4 Gerard M. Friters. Outer Mongolia and Its International position. Baltimore: John Hopkins press, 1949. p. 289.

5 М.Дүгэрсүрэн, Ц. Гомбосүрэн. XX зууны Монгол улсын гадаад бодлогын түүхэн тойм. УБ., 2004. 81-82-р тал.

1946 оны 8 дугаар сард Аюулгүйн Зөвлөлийн хурлаар өргөдөл гаргасан улс тус бүрээр хэлэлцэн санал хураахад Байнгын гишүүн 5 орноос АНУ, Их Британи Монголын хувьд татгалзсан байна. Харин байнгын гишүүдээс ЗХУ, Гоминьданы Хятад, Франц гурван улс дэмжиж саналаа өгчээ. Байнгын бус гишүүдээс Нидерланд татгалзаж, Египет, Австрали хоёр түдгэлзэж, Бразил, Мексик, Польш гурав дэмжиж саналаа өгсөн байна. Египетын төлөөлөгч түдгэлзэх болсон шалтгаанаа “БНМАУ-ын тухай мэдээлэл хомс” байгаагаар тайлбарласан байна.

ЗХУ-ын төлөөлөгч А.А.Громыко хэлэхдээ: “НҮБ-д элсэх тухай БНМАУ-ын өргөдлийг Зөвлөлт Засгийн газар дэмжиж байна. БНМАУ бол бат энх тайван, аюулгүй байдлын төлөө энх тайвныг эрхэмлэгч улс түмний нийтийн тэмцлийн үйлст чадлын хэрээр хувь нэмрээ оруулж чадах энх тайвныг эрхэмлэгч улс мөн гэж Зөвлөлт Засгийн газар үзэж байна... Монголын ард түмэн фашизм ба түрэмгийллийн эсрэг тэмцэлд Зөвлөлтийн ард түмэн, улаан армид идэвхтэй дэмжлэг үзүүлэв... БНМАУ-ын зүгээс Нэгдсэн үндэстнүүдэд үзүүлсэн бас нэг тусламж бол Манжуур дахь Японы Квантуны армийн эсрэг тулалдаанд Улаан армийн хамт Монголын 80 мянган цэрэг байлдсан явдал мөн. Энэ байлдаанд БНМАУ-ын цэргүүд Японы булаан эзлэгчидтэй эрэлхгээр тулалдаж, Японы дайчдыг бут ниргэхэд холбоотон улсуудад үнэт тусламж үзүүлжээ... Японы цэргүүдтэй хийсэн

байлдаануудад БНМАУ-ын цэргийн ангиуд хохирол үзэж, алагдсан, шархадсан ба сураггүй алга болсон хүний тоо 2039-д хүрчээ. Зөвхөн Монголын армийн эд материалын хохирол нь 50 сая доллар болжээ” гэж БНМАУ-ын өргөдлийг тууштай дэмжсэн байна.<sup>6</sup>

АНУ-ын төлөөлөгч Хершел Жонсон (Herschel V. Johnson) НҮБ-д гишүүн элсүүлэх явдал дээр универсализм хэмээх багцаар нь элсүүлэх зарчмыг хэрэглэхийн чухал учрыг илтгэсэн дэлгэрэнгүй үг хэлж байжээ. Америк, Английн төлөөлөгчид өргөдөл өгсөн 8 улсыг бүгдийг нь нэгэн зэрэг бөөнөөр нь хэлэлцүүлэх гэж их чармайж оролдсон байна. Бразил, Мексик, Египетын төлөөлөгчид, НҮБ-ын ЕНБД Трюгве Ли нар АНУ-ын төлөөлөгчийн саналыг дэмжжээ. Ийнхүү БНМАУ өргөдөл өгсөн бусад 7 улсын хамт нэгэн зэрэг багцаар НҮБ-д элсэх бодит боломж гарч ирсэн байна. Гэтэл ЗХУ-ын төлөөлөгч А.Громыко “Америкийн төлөөлөгчийн саналыг алдаатай бөгөөд хүлээн авч болохгүй учрыг тодорхой илчилж” энэ саналыг нураасан байна. А.Громыко “Би бодоход орнуудыг эд хогшилд ханддаг шиг хандлагаар авч үзэж болохгүй. Бүх орнуудыг түгээмлээр нэг маягаар үзэж, тийм журмаар НҮБ-д оруулж болохгүй. Уг хэрэгт хамаарагдах нөхцөл, баримтуудтай холбож, бид өргөдөл нэг бүрийг тусад нь авч үзвэл зохино” гэж зүтгэсэн байна.<sup>7</sup>

1947 оны 6 дугаар сард БНМАУ-Шинжааны хилийн районд Байтаг богд уул орчмоор, хятадууд Пэйташань

6 НҮБ ба Монгол Улс. Хууль зүйн Үндэсний төв. УБ., 2008. 12-13-р тал.

7 Мөн тэнд. 9-р тал.

хэмээх газар нэг талаас Гоминьданы хятад цэрэг болон тэдэнтэй нийлсэн Оспаны хасгийн дээрэмчид, нөгөө талаас Монголын хилийн цэргийн хооронд хэд хэдэн зэвсэгт мөргөлдөөн гарсан явдал дэлхий нийтийн анхаарлыг татаж, Монгол улсын НҮБ-д элсэхэд хүртэл сөргөөр нөлөөлсөн билээ.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөр БНМАУ-ын өргөдлийг дахин авч хэлэлцэх үед Гоминьданы хятадын төлөөлөгч Байтаг богд буюу Пэйташаний районд болсон хилийн будлианы асуудлыг сөхөж тавьжээ. Хятадын төлөөлөгч БНМАУ-ыг “өргөдөл гаргагч нь манай Шинжаанд зэвсэгт халдлага хийж, тэндэх Пэйташань районы нутгийг эзлэн авах түрэмгий оролдлого хийсэн” гэж яллаад “өргөдөл гаргагчийг энхийг эрхэмлэгч орон гэж үзэхгүй байна. Өмнө нь ч НҮБ-ын гишүүн байх болзлыг хангасан гэдэгт зарим эргэлзээ байсан төдийгүй одоо бол болзлуудыг хангаагүй гэдэг нь бүр тодорхой боллоо. Иймд бид ноднин жилийн адил гишүүнээр элсүүлэхийг дэмжих бололцоогүй” гэж мэдэгджээ.<sup>8</sup>

1947 оны 7 дугаар сарын 18-нд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд санал хураалт явагдахад ЗХУ, Польш, Сири гэсэн 3 улс зөвшөөрсөн санал өгч,

Гоминьданы Хятад, АНУ, Англи татгалзаж, Австрали, Бельги, Бразил, Колумби, Франц гэсэн 5 улс түдгэлзсэн санал өгчээ. Ийнхүү Байтаг Богдын мөргөлдөөнөөс үүдэн Монгол-Гоминьданы Хятадын харилцаа эрс хурцдаж, Чан Кайши, түүний дэглэм НҮБ-д Монголын хувьд ихээхэн хатуу байр суурь баримтлах болсон билээ.

Монголын Засгийн газар 1948 оны 10 дугаар сарын 11-нд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын нэр дээр илгээлт бичиг явуулж, урьд тавьсан хүсэлтээ шинээр илэрхийлжээ. Уг илгээлт бичигт “БНМАУ-ын Засгийн газрын даалгавраар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл ба Ерөнхий Ассамблейн III бага хуралд НҮБ-ын гишүүнд элсэх тухай БНМАУ-ын хүсэлтийг дахин тавьж хэлэлцүүлэхийг Танаас хүсэх завшаан надад тохиолдов. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн энэ бага хурал дээр манай хүсэлтийг хангах биз хэмээн БНМАУ-ын Засгийн газар, бүх Монголын ард түмэн ба миний бие итгэж байна” гэжээ.<sup>9</sup> Ийнхүү Байтаг Богдын хилийн мөргөлдөөнөөс үүдэн улс төрийн байдал хурцадсан үед ч БНМАУ-ын Засгийн газар НҮБ-д элсэн орох өргөдлөө хоёр дахь удаагаа өгч, НҮБ-д элсэн орох эрмэлзлээ илэрхийлсээр байжээ.

8 Gerard M. Friters. Ibid., p. 287.

9 ГХТА. Фонд 61, данс 01, хн. 22. БНМАУ-аас НҮБ-д элсэхээр бичсэн өргөдлүүд. 1946-1957. х. 3.

## Хоёр дахь үе: Солонгосын дайн ба НҮБ, БНМАУ-ын оролцоо

1950-1953 онд өрнөсөн Солонгосын дайны үед БНМАУ Хойд Солонгосын талд баттай зогсож, сэтгэл санаа, эд материалын үлэмж тусламж туслалцаа үзүүлсэн, үүний хаялга нөлөө НҮБ-д элсэх БНМАУ-ын хүчин чармайлтыг олон жилээр хойш нь татахад нөлөөлсөн билээ. Чан Кайшигийн Хятад АНУ-ын тэргүүлсэн НҮБ-ын цэргийн ажиллагааг бүх талаар дэмжиж, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд байнгын маргаан үүсгэж байсан төдийгүй Гадаад Монгол Хойд Солонгосын талд цэрэг илгээсэн мэтээр илэрхий мушгин гуйвуулсан баримт гаргаж байсныг АНУ-ын архивын баримтууд нотолж байна.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл 1950 оны 6 дугаар сарын 27-ны өдөр тогтоол гаргаж, түрэмгийллийг зогсоход НҮБ-ын бүхий л гишүүдийг хүчин чармайлт гаргахыг уриалжээ. Үүний дагуу АНУ-ын Ерөнхийлөгч Х.Трумэн мөн өдөр мэдэгдэл гаргаж, “коммунизм айлган сүрдүүлэх заагийг давж, тусгаар тогтносон үндэстнийг булаан эзлэх, зэвсэгт түрэмгийлэл, дайн үйлдэх болсныг Солонгост халдсан явдал харууллаа” хэмээн АНУ-ын агаарын болон тэнгисийн хүчийг Өмнөд Солонгосын цэрэгт туслахыг тушаасан тухай мэдэгджээ.<sup>10</sup> Аюулгүйн Зөвлөл 1950 оны 7 дугаар сарын 5-ны өдөр 84

тоот тогтоол гаргаж, АНУ тэргүүтэй НҮБ-ын мандаттай зэвсэгт хүчийг бүрэлдүүлж, НҮБ-ын далбаан дор БНАСАУ-ын эсрэг ажиллагааг явуулж, тус бүс нутагт олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сэргээн тогтоохыг зөвлөжээ.<sup>11</sup>

Монголын удирдлага олон улсын асуудлаар ЗХУ-тай нэг байр суурь баримталж байсан тул Солонгосын дайны анхны өдрөөс эхлэн дайны талаар БНАСАУ-ын байр суурийг бүрэн дэмжиж иржээ. Х.Чойбалсан Ким Ир Сенд 1950 оны 7 дугаар сарын 12-нд явуулсан цахилгаандаа: “Эрх чөлөөг эрмэлзэгч Солонгосын ард түмний эсрэг зэвсгээр халдан түрэмгийлсэн Ли Сын Мань урвагч бүлэг ба Америкийн империалистуудаас өөрийн орныг бүрэн чөлөөлөхийн төлөө тэмцэж байгаа Солонгосын ард түмний баатарлаг тэмцлийг Монголын ард түмэн гүнээ талархан ширтэн харж байна. БНАСАУ-ын бүрэн чөлөөлөгдөх өдөр айсуу гэдэгт Монголын ард түмэн гүнээ итгэж, Солонгосын ард түмний баатарлаг тэмцэлд цаашдын амжилт ба түргэн ялалтыг хүснэ” гэжээ.<sup>12</sup>

Нийт Солонгосын дайны хугацаанд БНМАУ нь ЗХУ, БНХАУ болон Европын ардын ардчилсан орнуудын нэгэн адил НҮБ-ын Аюулгүйн

10 Statement by the President, Truman on Korea”. June 27, 1950. History and Public Policy Program Digital Archive, Public Papers of the Presidents, Harry S. Truman, 1945-1953. <https://digitalarchive.wilsoncenter.org/116192>.

11 “UN Security Council Resolution 84,” July 05, 1950. History and Public Policy Program Digital Archive, United Nations, Department of Public Information, ed., Korea and the United Nations (Lake Success, NY: United Nations, 1950). <https://digitalarchive.wilsoncenter.org/document/117725>.

12 Ц.Батбаяр. Монгол ба Их гүрнүүд XX зуунд: II боть (1950-2000). “Соёмбо принтинг”, УБ., 2020. 204-р тал.

Зөвлөлийн удаа дараагийн тогтоолыг үл хайхарч, Хойт Солонгосыг дэмжин сэтгэл санааны болон эд материалын туслалцаа үзүүлж байв. Элчин сайд Ж.Ломбын номд өгүүлснээр 1951 оноос эхлэн дор хаяж 6 удаагийн бэлэглэлийн цуваа явуулж, 200 мянган толгой мал /адуу, үхэр, хонь, ямаа/, 5000 тонн улаан буудай, 7320 тонн хүнсний бүтээгдэхүүн, бэлэн хувцас зэргийг бэлэг болгон нийлүүлж байсны зэрэгцээ дайнд эцэг, эх нь үрэгдсэн 200-иад өнчин хүүхэд хүлээн авч асран хүмүүжүүлж, 30-аад оюутныг өөрийн их дээд сургуульд үнэ төлбөргүй сургаж байв.<sup>13</sup>

Чан Кайши-гийн Хятад БНМАУ-ыг Хойт Солонгосын талд ажиллаж, бүх талын туслалцаа үзүүлж байсан тул Солонгосын дайны “хамтран түрэмгийлэгч” гэж буруутгаж, БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх асуудлыг олон жилээр хойш татах нэг шалтаг болгон ашигласан билээ. Тухайлбал, Чан Кайши 1961 оны 6 дугаар сарын 9-нд АНУ-ын дэд Ерөнхийлөгч Линдон Жонсонд бичсэн захидалдаа БНМАУ-ыг НҮБ-д элсүүлж болохгүй, түүнийг АНУ хүлээн зөвшөөрч болохгүй шалтгааныг маш олон чиглэлээр үндэслэж АНУ-ын засаг захиргааг ятгасан байна. Чан Кайши АНУ-ын засаг захиргаа “Гадаад Монголын

коммунист дэглэм”-тэй дипломат харилцаа тогтоохоор хүчин чармайлт гаргаж буйг эрс няцаагаад Гадаад Монгол бол ЗХУ-ын “илт тоглоомын хүүхэддэй” бөгөөд Солонгосын дайны “хамтран түрэмгийлэгч” /an outright puppet of the Soviet Union and a co-aggressor in the Korean war/ хэмээн буруутгаж байв.<sup>14</sup>

ЗХУ-ын төлөөлөгч НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл, түүний Тусгай хороо, Ерөнхий Ассамблейн чуулган дээр универсализмын зарчмыг мөрдлөг болгон 1949 онд 13 орныг, 1951 онд 12 орныг, 1952 онд 14 орныг, 1954 онд 14 орныг нэгэн зэрэг элсүүлэх саналыг оруулж байсан боловч Өрнөдийн орнуудын байр сууриас шалтгаалан Аюулгүйн Зөвлөлийн дэмжлэг олж авч чадахгүй байлаа. Олон улсын харилцаа хурцадсан энэ үед НҮБ-д шинэ гишүүн элсүүлэхэд хориг хэрэглэхгүй байх тухай Ираны санал, Аюулгүйн Зөвлөлийн санамжгүйгээр Ерөнхий Ассамблейгаар шийдвэрлэх тухай Аргентины санал тус тус гарч олон улсын шүүх, Ерөнхий Ассамблейгаар хэлэлцэгдэж байв. НҮБ-д шинээр гишүүн элсүүлэх асуудлын мухардал Их гүрнүүдийн сөргөлдөөнөөс болж 1955 он хүртэл гүнзгийрэн үргэлжилсэн байна.

13 Монгол Улс, БНАСАУ-ын харилцаа: Нэгэн жаран, эмтгэсэн Ж.Ломбо, Пхеньян, 2007, 142-р тал

14 Letter from Chiang Kai-shek to Vice-President L. Johnson, June 9, 1961. JFKNSF-026-005-p0015 4. John F. Kennedy Presidential Library and Museum. <https://jfklibrary.org>

### Гурав дахь үе: ЗХУ, АНУ ба Монголын гишүүнчлэл (1955-1961 он)

1950-иад оны дундаас БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх нь Зөвлөлт-Америкийн төдийгүй, АНУ-Тайваний Хятадын харилцааны эмзэг хөндүүр асуудал болон тавигдах болсныг түүхч Р.Болд бичжээ. АНУ, ЗХУ, Британи, Францын ГЯЯ-ны сайд нар Женевт 1955 оны 11 дүгээр сард НҮБ-ын гишүүнчлэлийн асуудлаар уулзав. ЗХУ, Канад хоёр БНМАУ-ыг оролцуулан социалист 5 улсыг багтаасан 18 орныг НҮБ-ын гишүүнээр багцаар нь элсүүлэх саналыг 1955 онд дэвшүүлээд байв.<sup>15</sup>

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жон Фостер Даллес ЗХУ-ын ГЯЯ-ны сайд В. Молотовтай уулзаж, БНМАУ-ын гишүүнчлэлийн асуудлаар 1955 оны 11 дүгээр сарын 13-нд дэлгэрэнгүй ярилцжээ. Даллес БНМАУ-ыг 18 орны багцаас хасахыг хүссэн байна. Молотов БНМАУ-ын гишүүнчлэлийг үгүйсгэж болохгүй, Энэтхэг саяхан Монголыг хүлээн зөвшөөрсөн гэж ярьсан байна. Даллес Бандунгийн уулзалтад Гадаад Монголыг урьж оролцуулсангүй, тус бага хурлын зөвлөмжид Монголын нэр ороогүй байна гэж маргасан байна. Дөрвөн гүрний Гадаад хэргийн сайд нарын уулзалт үр дүнгүй дуусав.

1950-иад оны дундуур НҮБ-д шинээр гишүүн элсүүлэх асуудал мухардалд орсон тул “Universality” буюу багцаар нь элсүүлэх түгээмэл зарчмыг зүйтэйд тооцож НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Трюгве

Ли ч уг зарчмыг дэмжих болжээ. Египет, Нидерланд, Перу гурван орны төлөөлөгчид багтсан “Сайн санааны хороо” /Committee of Good Offices/ гэдгийг 1953 оны 10 дугаар сард байгуулж, уг Хорооноос шинээр гишүүн элсүүлэхэд түгээмэл зарчмыг хэрэглэх тухай зөвлөмж боловсруулжээ. Канад тэргүүтэй НҮБ-ын гишүүн 28 орны санаачилсан НҮБ-д 18 орныг багцаар нь элсүүлэх тухай хамтарсан тогтоолын төслийг 1955 оны 11 дүгээр сарын 16-нд Ерөнхий Ассамблейд өргөн барьсан байна. Энэхүү 18 гишүүн нэгэн зэрэг элсүүлэх тогтоолын төслийг “1945 онд НҮБ байгуулагдсанаас хойших хоёрдахь чухал үйл явдал” гэж НҮБ-ын хүрээнд өргөн хэлэлцэгдэж байсан байна.<sup>16</sup>

1955 оны 12 дугаар сард Ерөнхий Ассамблейн гишүүдийн 52 нь 18 улсыг багцаар нь НҮБ-д элсүүлэх тухай Канад зэрэг 28 орны саналыг дэмжиж байв. Гэтэл уул Зөвлөмжийг Аюулгүйн Зөвлөлөөр хэлэлцэхэд Чан Кайши-гийн төлөөлөгч БНМАУ-ын эсрэг хориг тавьсан тул ЗХУ-ын төлөөлөгч Япон, Испани хоёрыг НҮБ-д авах зөвлөмж өгөхөөс татгалзаж улмаар 18 улсыг зэрэг элсүүлэх асуудал нурсан байна. Аюулгүйн Зөвлөлийн 12 дугаар сарын 15-ны онцгой хуралдаан дээр ЗХУ-ын төлөөлөгч БНМАУ, Япон хоёроос бусад 16 улсыг НҮБ-д элсүүлэх шинэ санал тавьсныг Аюулгүйн Зөвлөл, Ерөнхий Ассамблейн дийлэнх олонх зөвшөөрснөөр тэдгээр 16 улс НҮБ-ын

15 Р.Болд. Монголын тусгаар тогтнол ба АНУ. /1910-1973/. УБ., 2008. 264-265-р тал.

16 Leo Gross. Progress towards Universality of Membership in the United Nations. *The American Journal of International Law*, Vol. 50, No 4 (oct., 1956), pp. 791-827



гишүүн болжээ. Монгол, Японыг дараа жилийн НҮБ-ын ээлжит чуулганаар элсүүлэх Зөвлөмжийн төслийг ЗХУ-ын төлөөлөгч оруулж ирэхэд АНУ, Английн төлөөлөгчид эсэргүүцсэн байна. АНУ-ын төлөөлөгч ноён Х.Лоуж /Mr. Henry Cabot Lodge/ “Япон, Гадаад Монголыг нэгэн зиндаанд тавьж болохгүй. Япон нь дэлхийн эдийн засаг, соёлд чухал хувь нэмэр оруулсан байхад Монгол бол “газар зүйн ойлголт” юм гэж үгүйсгэж байжээ.<sup>17</sup>

Оросын судлаач И.Гайдук ЗХУ-ын удирдагч И.В.Сталин улс төрийн тайзнаас хальсан, НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар шинэ хүн Даг Хаммершельд сонгогдсоноор НҮБ-ыг тойрсон сөргөлдөөн, ялангуяа шинэ гишүүн элсүүлэх асуудалтай холбогдсон мухардал аажим аажмаар намжиж, НҮБ-ыг өргөтгөх, НҮБ-ын дүрэмд туссан универсализмын зарчмыг сэргээх талаар цоо шинэ уур амьсгал үүссэнийг бичжээ.<sup>18</sup>

ЗХУ 1955 оноос эхлэн НҮБ дахь гишүүнчлэлийг өргөтгөх, ялангуяа БНХАУ болон БНМАУ-ыг НҮБ-д хууль ёсны байр суурийг эзлүүлэх, түүнчлэн шинээр тусгаар тогтнолоо олсон Ази-Африкийн орнуудыг НҮБ-д элсүүлэхийг өөрийн гадаад бодлогын нэг чухал зорилт болон дэвшүүлсэн юм. ЗХУ 1955 онд Бандунгт болсон Ази-Африкийн орнуудын бага хурал, Кайрт болсон Арабын орнуудын бага хурлыг хүчтэй дэмжсэнээс гадна

ЗХУКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Н.С.Хрущев нийгмийн өөр өөр байгуулалтай орнууд “энх тайвнаар зэрэгцэн орших”, мөн шинээр тусгаар тогтнолоо олсон Ази-Африк-Латин Америкийн орнууд “энх тайвны шинэ бүс нутаг” болох тухай зарчмын шинэ үзэл санаанууд дэвшүүлсэн билээ.<sup>19</sup>

1956 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Аюулгүйн Зөвлөлөөр БНМАУ-ыг гишүүнээр элсүүлэхийн төлөө ЗХУ, Югослав, Иран, Перу саналаа өгч, Чан Кайши ба Батистын Кубын төлөөлөгч татгалзаж, Австрали, Бельги, Англи, АНУ, Франц түдгэлзсэн байна.

АНУ-ын Ерөнхийлөгч Жон Кеннеди-гийн засаг захиргаа 1961 оноос БНМАУ-ыг хүлээн зөвшөөрөх чиг шугам баримтлах болсонтой холбогдуулан НҮБ-ын хүрээнд БНМАУ-д хандах хандлагаа хянаж үзжээ. АНУ-ын Байнгын төлөөлөгчийн орлогч Ч. Йост /Charles W. Yost/ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1961 оны 4 дүгээр сарын 19-ний бүгд хуралдаан дээр АНУ-ын шинэ засаг захиргаа “Гадаад Монгол” буюу БНМАУ-ын талаар шинэ байр суурь баримтлах болсноо зарлав. АНУ Гадаад Монгол нь тусгаар тогтносон улсын шалгуурыг даах эсэхийг тогтоож чадвал түүнийг НҮБ-д гишүүнээр элсэхийг дэмжих төдийгүй, дэмжих тогтоолыг хамтран зохиогчоор оролцох болно гэжээ.

Ерөнхийлөгч Кеннеди асуудлыг “эрүүл саруулаар” авч үзэж БНМАУ-д вето хориг тавихгүй байхыг хүссэн

17 Монголын дипломатын нэвтэрхий толь бичиг. Дэд боть, УБ., 2014. 484-485-р тал.

18 И.В.Гайдук. В лабиринтах “холодной войны”: СССР и США в ООН, 1945-1965 гг. М.: ИВИ РАН, 2012.с. 215-220.

19 Н.Верг. История Советского государства 1900-1991. Второе исправленное издание. Перевод с французского. “Прогресс-Академия”. М., 1995. с. 386-391.

албан захидлыг 1961 оны намар Чан Кайшид илгээсэн байна. Кеннеди 1961 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Чан Кайшид илгээсэн захидалдаа энэхүү байр сууриа маш тодорхой илэрхийлжээ.

Жон Кеннеди захидалдаа “Чөлөөт ертөнц болон коммунизмын хоорондын олон улсын тэмцэлд Нэгдсэн Үндэстний байгууллага чухал тэмцлийн талбар болж буй”-г тэмдэглээд бидний нийтлэг зорилго бол НҮБ дахь Гоминьданы Хятадын байр суурийг хэвээр хадгалах, харин БНХАУ-ыг НҮБ-аас ангид байлгах хэмээн тодорхойлжээ. Кеннеди мөн уг захидалдаа “Гадаад Монголын” талаарх байр сууриа ингэж тодорхойлжээ. “Хэрвээ танай Засгийн газар Гадаад Монголыг НҮБ-д элсэхийг хориглож вето эрхээ хэрэглэх аваас бид НҮБ-д дээрх зорилгодоо хүрэх олонхийн дэмжлэгийг авч чадахгүй байх асар их аюул байгааг би танд цохон хэлэхгүй бол Тантай илэн далангүй байсангүй гэж өөрийгөө зэмлэхэд хүрнэ” хэмээн учирласан байна. Кеннеди цааш нь Африкаас Мавританийг НҮБ-д элсүүлэх асуудал БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх асуудалтай зэрэг тавигдаж байгаа учраас энэ хоёр орны хувьд маш эвтэй хандахгүй бол Африкийн орнуудын дургүйцлийг төрүүлж НҮБ-д Гоминьданы Хятадын байх эсэх асуудал ч яригдана гэдгийг давхар анхааруулжээ. Тэрбээр Чан Кайшид НҮБ-аас явж, БНХАУ-д байр сууриа тавьж өгөх үү, эсвэл

Гадаад Монголыг дэмжиж, Африкийн орнуудын дэмжлэгийг авснаар НҮБ-д байр сууриа хадгалан үлдэх үү гэсэн сонголт л үлдэж байгааг цохон тэмдэглэжээ.<sup>20</sup>

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл 1961 оны 9 дүгээр сард НҮБ-д манай улсыг элсэн орох асуудлыг хэлэлцэхэд оролцох төлөөлөгчдийг ГЯЯ-ны нэгдүгээр орлогч сайд Д.Цэвэгмид /тэргүүн/, Б.Жаргалсайхан, Б.Дашцэрэн, О.Дамдиндорж нарын бүрэлдэхүүнтэй баталжээ. Тэдний замын тэмдэглэлд өгүүлснээр 1961 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Нью Йорк хотноо буухад НҮБ-ын дэргэдэх ЗХУ-ын Байнгын төлөөлөгч В.А.Зорин ажилтнуудын хамт угтан авчээ. Тэд 23-ны өглөө Зоринтой уулзахад: “Чан Кайшистыг санал хураахад оролцохгүй болгосон байгаа. БНМАУ-ын төлөө 9 улс саналаа өгч, Америк түдгэлзэх, Чан Кайшист үл оролцох төлөвтэй байгаа. Бид нэгдүгээрт Монголын асуудлыг хэлэлцээд дараа нь Мавританы асуудалд орохоор бодож байгаа” гэжээ. Аюулгүйн Зөвлөлөөр Монгол, Мавританы хэний асуудлыг түрүүлж хэлэлцүүлэх асуудал эцсийн мөч хүртэл ЗХУ, АНУ-ын төлөөлөгчдийн дунд маргаантай хэвээр байжээ. ЗХУ-ын төлөөлөгч БНМАУ-ын асуудлыг нэгдүгээрт хэлэлцүүлэхийг АНУ-ын НҮБ дэх Байнгын төлөөлөгч Стивенсонд /Ambassador Adlai Stevenson/ хүчтэй шахаж, Ерөнхийлөгч Кеннедитэй хүртэл яриулж байжээ.<sup>21</sup>

20 Letter from President John F. Kennedy to President Chiang Kai-shek, August 15, 1961. JFKNSF-026-005-p0047. Papers of John F. Kennedy. John F. Kennedy Presidential Library and Museum. <https://jfklibrary.org>

21 ГХТА. Фонд 61, данс 01, хн.28. БНМАУ НҮБ-д элсэн орсон тухай баримт. х. 34-37.

1961 оны 10 дугаар сарын 25-ны НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 971 дүгээр хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлээс үзвэл БНМАУ-ын өргөдлийг дараах байдлаар авч хэлэлцсэн байна. Туркийн төлөөлөгч хуралдааныг даргалж байсан бөгөөд эхлээд БНМАУ-ын өргөдлийг авч хэлэлцээд санал хураах, дараа нь Исламын Бүгд Найрамдах Мавритани улсын өргөдлийг авч хэлэлцэх дэгийн санал оруулсан байна. Үүний дагуу НҮБ-ын дэргэд суух ЗХУ-ын Байнгын төлөөлөгч В.А.Зорин НҮБ-д БНМАУ-ыг авах талаар ЗХУ-аас оруулсан тогтоолын төслийг танилцуулж, Аюулгүйн Зөвлөлийн гишүүдийг дэмжихийг уриалсан байна. Зорин мөн БНМАУ-ын өргөдөл сайнаар шийдэгдэх аваас Мавританийг НҮБ-д элсүүлэхэд саад хийхгүй гэж мэдэгджээ.

В.А.Зорин хэлсэн үгэндээ БНМАУ нэн эртний түүхтэй улсын нэг болохыг дурдаад тус улс нь одоо дэлхийн хүн амын талаас илүүг эзлэх 4 тивийн 21 улстай дипломат харилцаатай болоод байгааг тэмдэглэв. БНМАУ НҮБ-д элсэх тухай өргөдлөө хамгийн анх өгсөн улсын нэг мөн бөгөөд тус улсыг элсүүлэх тухай Ерөнхий Ассамблейгаас нэг бус удаа санамж гаргасан боловч тодорхой шалтгаанаар одоо хүртэл “НҮБ-ын ханын гадна байна” гэжээ. Үүнтэй холбогдуулан Ерөнхий Ассамблейгаас энэ оны 4 дүгээр сарын 20-нд гаргасан 1602-р шийдвэрийг сануулахад болох юм. Тэрбээр: “БНМАУ-ыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын

гишүүнд элсүүлэх асуудлыг зөвөөр шийдвэрлэж, 1946 оноос эхлэн НҮБ-д орохыг хүлээж байгаа энэ оронд шударга бусаар хандаж байсан явдлыг эцэс болгохыг Зөвлөлтийн төлөөлөгчид Аюулгүйн Зөвлөлийн гишүүдэд уриалж байна” гэсэн байна.<sup>22</sup>

Чан Кайши-гийн төлөөлөгч хэлсэн үгэндээ Монгол, Хятад хоёр нь олон зуун жилийн турш, ялангуяа XIII зуунаас эхлэн улс төрийн нэг гэр бүлд багтаж байсан юм хэмээн нотлохыг оролдоод “Гадаад Монгол”-ыг түрэмгийлэх гэсэн Хаант Орос, Зөвлөлт Оросын бодлогыг олон баримтаар нотлон үзүүлэхийг хичээсэн байна. Тэрбээр “Гадаад Монгол бол тусгаар тогтносон нэрээр халхавчлагдсан боловч үнэн хэрэг дээрээ Зөвлөлтийн колони юм. Гадаад Монголын сүүлийн 40 жилийн түүх бол ЗХУ-аас гардан явуулж байгаа шинэ колоничлол ба империализмын хэлбэр юм” гэж хүртэл мэдэгджээ. Мөн эцэст нь Мавритани болон Африкийн орнуудын хүсэлтийг хүндэтгэн “Гадаад Монголыг” элсүүлэх санал хураалтад оролцохгүй, түүнд хориг тавих эрхээ эдлэхгүй гэж мэдэгджээ. Тухайн үед Чан Кайши-гийн Хятадын НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүний статус нь хууль эрх зүйн хувьд ноцтой хөндөгдөөд байсан үед Мавритани, түүний цаана зогсож байсан Африкийн олон орны шахалт шаардлагад автан БНМАУ-ын төлөө санал хураалтад оролцохгүй тийм “нэр цэвэр үлдэх” аргыг сонгож авахаас өөр аргагүй байдалд орсон байна.

22 ГХТА, фонд 61, данс 01, хн. 28. БНМАУ НҮБ-д элсэн орсон тухай баримт. х. 4-7

АНУ-ын төлөөлөгч Ч.Йост /Charles W. Yost, Deputy Permanent Representative/ хэлсэн үгэндээ БНМАУ-ын өргөдлийн тухайд: "...үүнээс нэлээд өмнө АНУ өөрөө ямар саналтай байгаагаас үл хамааран НҮБ-д Гадаад Монголыг элсүүлэх явдалд ямар ч саад хийхгүй гэж ноён Стивенсон тус Аюулгүйн Зөвлөлд мэдэгдсэн билээ. Үүний шалтгаан нь нийтэд тодорхой байгаа. Өнгөрсөн 4 дүгээр сард Ерөнхий Ассамблей Гадаад Монгол Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн байж чадах улс гэж дүгнэснийг АНУ анхааралдаа авсан юм. Иймээс бид Ерөнхий Ассамблейн энэ шийдвэрийг хүндэтгэж энэ асуудал энд болоод Ерөнхий Ассамблейд хэлэлцэгдэх үед ямар ч саад хийхгүй болой. Иймээс Гадаад Монголыг элсүүлэх тухай тогтоолд санал өргөхөд АНУ түдгэлзэх болно" гэдгээ ил тод мэдэгджээ.

Ийнхүү 1961 оны 10 дугаар сарын 25-ны өдөр НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөр Монгол, Мавритани хоёр

улсыг НҮБ-д нэгэн зэрэг элсүүлэх асуудлаар санал хураалт явагдсан байна. БНМАУ-ыг элсүүлэхийг зөвлөмж болгосон тогтоолын төслийг ЗХУ, Англи, Франц, Цейлон, Чили, Нэгдсэн Араб, Эквадор, Либериа, Турк улс тус бүр дэмжиж АНУ түдгэлзсэн бөгөөд Чан Кайшийн төлөөлөгч танхимаас гарч санал хураалтад оролцсонгүй.

1961 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 15 цагт Ерөнхий Ассамблей хуралдаж, түүн дээр Монгол, Мавританыг элсүүлэх асуудлыг хэлэлцэв. ЗХУ тэргүүтэй 23 улсын төлөөлөгчдийн оруулсан тогтоолын төслөөр БНМАУ-ыг санал хураалгүй нэгэн дуугаар алга ташин батлахад НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газрын протоколын дарга Монголын төлөөлөгчдийг түр ажиглагчийн байрнаас урьж, "Монгол" гэсэн хаяг бүхий суудалд залж суулгав. Ингэж манай улсын төлөөлөгчид НҮБ-д хууль ёсны байраа эзлэн БНМАУ НҮБ-ын 101 дэх гишүүнээр элссэн билээ.

## Дүгнэлт

Дэлхийн бодлогод гол нөлөө үзүүлж байсан АНУ, ЗХУ, Их Британи, Франц тэргүүтэй орнууд НҮБ-д тус тусын “тоглолт” явуулж, НҮБ-д шинээр гишүүн элсүүлэх асуудалд үзэл суртлын байр сууринаас хандаж, НҮБ-д өөрийн талын байр суурийг баримтлагч улсуудын тоог өргөтгөх үүднээс “наймаалцах”, ар хударгаар хэлэлцэн тохирох зэрэг явуургүй аргыг хэрэглэж байлаа. БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх асуудлыг олон жилээр хойш татсан хүчин зүйл бол гарцаагүй Чан Кайши-гийн Хятад буюу Тайванийн арлын байр суурь байсан юм. Чан Кайши 1946 онд БНМАУ-ыг НҮБ-д элсэх асуудалд эргэлзэнгүй хандаж байсан боловч 1947 оноос эхлэн Байтаг Богдын тулаанаас болж байр сууриа эрс чангатган БНМАУ-ыг “түрэмгийлэгч улс” хэмээн НҮБ-ын индэр дээрээс зарлаж байжээ. 1950-1953 оны Солонгосын дайны үеэр БНМАУ социалист орнуудын зарчимд нийцүүлэн БНАСАУ-ыг бүрэн дүүрэн дэмжиж, эд материалын тусламж үзүүлэх болсонд өширхөж, “ЗХУ-ын колони, хараат, тоглоомын улс” хэмээх нэр хаяг зүүж, Солонгосын дайнд НҮБ-ын мандаттай орнуудын эсрэг БНАСАУ-ын хамт “хамтран түрэмгийлэгч” орон хэмээн буруутгаж АНУ болон Өрнөдийн бусад орнуудад БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэхгүй байх үүднээс хүчтэй дарамт үзүүлж чадаж байв.

1950-иад оны сүүлч, 1960-аад оны эхээр НҮБ дахь их гүрнүүд болон хуучин колони, хараат байсан

Ази, Африк, Латин Америкийн улсуудын хоорондын хүчний харьцаа өөрчлөгдсөн байна. ЗХУ, түүний шинэ удирдлага Н.С.Хрушев 1950-иад оны дундаас нийгмийн өөр өөр байгуулалтай улсууд “энх тайвнаар зэрэгцэн орших бодлого” явуулж, НҮБ-ын үйл ажиллагаанд ч цоо шинээр хандах болов. Москва, Вашингтон аль аль нь НҮБ дахь нэг талаас Европ, Америк тивийн орнууд, нөгөө талаас Ази, Африкийн шинээр тусгаар тогтносон орнуудын хүчний тэнцвэр өөрчлөгдөх болсныг мэдэрч, НҮБ-д шинээр гишүүн элсүүлэх асуудалд уян хатан хандах болсон билээ.

Ийм нөхцөлд АНУ, Их Британи, Франц тэргүүтэй улсууд БНМАУ-ын талаарх бодлогодоо тус бүр залруулга хийж, Их Британи, Франц БНМАУ-ыг НҮБ-д элсэхийг дэмжих, АНУ БНМАУ-ын НҮБ-д элсэхэд саад хийхгүй, түдгэлзэх санал өгөхөө ил тод зарласан байна. Ийнхүү ЗХУ-ын оруулсан тогтоолын төслийг Аюулгүйн Зөвлөлийн байнгын болон байнгын бус гишүүн орнууд дэмжиж, АНУ түдгэлзэн, Тайвань танхимаас гарч санал хураалтад оролцоогүй тул БНМАУ 1961 оны 10 дугаар сарын 27-ний өдөр буюу одоогоос нэгэн жарны өмнө НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болж, НҮБ-д хууль ёсны суудлаа эзэлж чадсан билээ. БНМАУ НҮБ-ын дүрмийн зорилт, зарчмыг зөвшөөрөн биелүүлэх эрмэлзэл төгс, олон улсын харилцааны чадвар бүрэн субъект мөн гэдгээ ийнхүү дэлхий нийтийн өмнө батлан харуулав.

## Ашигласан материал

### Нэг. Архивын эх сурвалж

1. Монгол Улсын Гадаад харилцааны төв архив /ГХТА/. Фонд 61, данс 01, хн. 22. БНМАУ-аас НҮБ-д элсэхээр бичсэн өргөдлүүд. 1946-1957. х. 7.
2. ГХТА. Фонд 61, данс 01, хн.28. БНМАУ НҮБ-д элсэн орсон тухай баримт. х. 167.
3. НҮБ ба Монгол Улс. Баримтын эмхэтгэл. Хууль зүйн Үндэсний төв. УБ., 2008.
4. Монгол Улс, БНАСАУ-ын харилцаа: Нэгэн жаран. /Баримтын эмхэтгэл/ эмхэтгэсэн Ж. Ломбо, Пхеньян, 2007.

### Хоёр. Цахим архивын баримтууд

1. “Statement by the President, Truman on Korea”. June 27, 1950. History and Public Policy Program Digital Archive, Public Papers of the Presidents, Harry S. Truman, 1945-1953. <https://digitalarchive.wilsoncenter.org/116192>.
2. “UN Security Council Resolution 84,” July 05, 1950. History and Public Policy Program Digital Archive, United Nations, Department of Public Information, ed., Korea and the United Nations (Lake Success, NY: United Nations, 1950) <https://digitalarchive.wilsoncenter.org/document/117725>.
3. Letter from Chiang Kai-shek to Vice-President L. Johnson, June 9, 1961. JFKNSF-026-005-p0015 4. John F. Kennedy Presidential Library and Museum. <https://jfklibrary.org>
4. Letter from President John F. Kennedy to President Chiang Kai-shek, August 15, 1961. JFKNSF-026-005-p0047. Papers of John F. Kennedy. John F. Kennedy Presidential Library and Museum. <https://jfklibrary.org>

### Гурав. Судалгааны ном, өгүүлэл:

1. Р.Болд. Монголын тусгаар тогтнол ба АНУ. /1910-1973/. УБ.: “Нэлко” хэвлэл, 2008.
2. Ц.Батбаяр. Монгол ба Их гүрнүүд XX зуунд: II боть (1950-2000). “Соёмбо принтинг”, УБ., 2020.
3. М.Дүгэрсүрэн, Ц.Гомбосүрэн. XX зууны Монгол улсын гадаад бодлогын түүхэн тойм. УБ., 2004.
4. Монголын дипломатын нэвтэрхий толь бичиг. Дэд боть, УБ., 2014.
5. И.В.Гайдук. В лабиринтах “холодной войны”: СССР и США в ООН, 1945-1965 гг. М.: ИВИ РАН, 2012.
6. Н.Верт. История Советского государства 1900-1991. Второе исправленное издание. Перевод с французского. “Прогресс-Академия”. М., 1995.
7. Gerard M. Friters. Outer Mongolia and Its International position. Baltimore: John Hopkins press, 1949.
8. Leo Gross. Progress towards Universality of Membership in the United Nations. *The American Journal of International Law*, Vol. 50, No 4 (oct., 1956), pp. 791-827

### Дөрөв. Тогтмол хэвлэл

1. “Үнэн” сонин. 1946-1961 он.

## The Issue of “Outer Mongolia” at the United Nations in 1946-1961: The evolution of Soviet and American approaches towards the MPR’s membership issue

**Batbayar Tsedendamba**

*Academician, Sc.D History, IHE, MAS, Ulaanbaatar, Mongolia  
tsedendamba.bud@gmail.com*

**Abstract:** *The article explores the aspects of the interaction between the USSR and the USA on the issue of “Outer Mongolia” as it was called within the United Nations at the first stage of the Cold War. The author divided the issue of “Outer Mongolia” at the UN during that period into three periods: the first period from 1946 to 1948, the second period from 1950 to 1953, i.e. during the Korean war, the final, third one from 1955 to 1961. The author shows how the manipulation of the United Nations by the great powers in their own political interests impeded the settlement of the global issues and postponed admission of the countries such as Mongolian People’s Republic (so called Outer Mongolia) to the UN for many years. The admission to the UN for Mongolia was a matter of national pride as a sovereign nation, and gaining legitimacy in the world affairs and building a reputation in the international arena. The nature of the dialogue between Moscow and Washington played a key role in solving global and regional issues, and aspirations of small countries like the Mongolian People’s Republic had a negligible weight in international affairs.*

**Keywords:** *UN, Mongolia, the USA, the USSR, Cold War, veto power, Korean War, the MPR’s membership issue*

<i>The day of submission:</i>	2021.05.04
<i>Completion of review:</i>	2021.06.30
<i>Final decision for acceptance:</i>	2021.07.05